



ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 478

Батноров сум

Архидалтгүй Батноровчууд  
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй найман нэрийн хүнсний дэлгүүрт хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажлын үр дүнг танилцуулахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Ч.Чинхүсэл), Хэсгийн төлөөлөгч дэслэгч (Г.Ганбаяр) нарт үүрэг болгосугай.

2. Архины хамааралтай иргэдийн гэрээр хяналт шалгалтын ажил зохион байгуулах, архины албадан эмчилгээнд хамрагдах иргэдийн судалгааг гаргахыг багийн Засаг дарга нар болон Хүүхэд гэр бүл хамгааллын хамтарсан баг, Хэсгийн төлөөлөгч нарт үүрэг болгосугай.

3. Төрийн албан хаагчид төрсөн өдөр, баасан гараг, тэмдэглэлт баяр болон тэмцээн уралдаан арга хэмжээнүүдийг архигүй зохион байгуулахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Нийтийн биеийн тамирыг дэмжих зорилгоор спорт заал, фитнес клубийг ажиллуулан, үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Биеийн тамирын арга зүйч (Ц.Тайванхүү)-д даалгасугай.

5. Нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баяр ёслолыг (цааан сар, олон улсын эмэгтэйчүүдийн баяр, цэргийн баяр гэх мэт) архигүй тэмдэглэж байхыг нийт иргэдэд уриалсугай.

6. Архидалтын эсрэг сэтгэл зүйн эмчилгээ, сургалт зохион байгуулахыг Хууль, эрх зүйн мэргэжилтэн (А.Эрдэнэтуюя), Хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын нийгмийн ажилтан (Г.Бадамханд) нарт үүрэг болгосугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Д.Бямбацогт)-д даалгасугай.

ДАРГА

Г.ОТГОНБАЯР

230425199